

# BSI байгууллагын тухай

Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ  
Түүх, баримтууд ба тайлбар  
Боломжууд ба саналууд  
Давуу талууд ба онцлог



**АГУУЛГА**

<b>BSI</b> .....	<b>2</b>
<b>BSI-ийн түүх</b> .....	<b>2</b>
<b>BSI-ийн зах зээл</b> .....	<b>2</b>
<b>Бизнесийн ертөнц дэхь нэр хүнд</b> .....	<b>3</b>
<b>Мэргэжлийн хүрээлэл дэхь нэр хүнд</b> .....	<b>3</b>
<b>Клиент байгууллагуудын амжилтанд нөлөөлөх байдал</b> .....	<b>3</b>
<b>Ил тод байдал</b> .....	<b>4</b>
<b>Нэр хүнд болон статус</b> .....	<b>4</b>
<b>Дэлхий даяарх үйл ажиллагаа</b> .....	Error! Bookmark not defined.
<b>Хамтран ажилладаг зөвлөхүүдийн сүлжээ</b> .....	<b>4</b>
<b>Монгол дахь бидний түншлэл</b> .....	<b>4</b>
<b>BSI-ийн төлөөлөл</b> .....	Error! Bookmark not defined.
<b>Хавсралт А. BSI-ийн гэрчилгээний жишээ</b> .....	<b>6</b>
.....	<b>6</b>
<b>Хавсралт В. Монголд сургалт, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх стандартууд</b> .....	<b>7</b>



## BSI.

### BSI-ийн түүх

British Standards Institution – Британийн Стандартын Байгууллага (BSI) нь дэлхийн ууган, домогт, хамгийн нэр хүндтэй стандартын байгууллагаар зүй ёсоор тооцогддог.

100 гаруй жилийн амжилттай хөгжлийн явцад BSI нь үндэсний байгууллагаас орчин үеийн стандартууд, сургалт боловсрол болон баталгаажуулалтын дэлхийн хэмжээний хөгжлийн хандлагыг тодорхойлогч олон улсын байгууллага болон хөгжсөн юм.

BSI нь олон улсын стандартын ISO байгууллагыг болон итгэмжлэлийн UKAS байгууллагуудыг үүсгэн байгуулагч нь ба эдгээр байгууллагуудын хөгжилд BSI-ийн гүйцэтгэсэн үүрэг роль болон ач гавъяаг үнэлж баршгүй билээ.

Сүүлийн 10 жилийн хугацаанд BSI нь өөрийн нэр дор АНУ-ын KPMG болон First Advantage Co., Германы Eurocat болон NIZ Cert, Австралийн Benchmark Cerification, Британы Germanisher Lloyd (GLSC) зэрэг компаниудын баталгаажуулалтын бизнесийг нэгтгэсэнээр өөрийн байр суурийг хэмжээлшгүй бэхжүүлсэн юм.

### BSI-ийн үйлчилгээ

BSI нь чанар, бүтээмж, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага, нэр хүндийн хамгаалалт зэргийг сайжруулах болон тогтвортой байдлыг дээшлүүлэх салбарт төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр үйлчилгээ нь дэлхийн шилдэг практикийг нэгтгэсэн стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэхтэй холбоотой. Үндсэн чадварын салбарууд гэвэл:

- Байгууллагын, салбарын, үндэсний болон олон улсын стандартуудыг боловсруулах
- Удирдлагын тогтолцооны аудит болон сертификатчилал (баталгаажуулалт)
- Бүтээгдэхүүн ба үйлчилгээний түршилт болон баталгаажуулалт
- Эрсдэлийн тохирол ба удирдлагыг хангах
- Сургалтуудыг оролцуулсан боловсролын үйл ажиллагаа

BSI Хатан хааны зарлигаар байгуулагдсан ашгийн төлөө бус байгааллагын хувьд өөрийн шийдвэрүүдэд гадны аливаа нөлөөллөөс ангид буюу хараат бус байдлыг эрхэмлэдэг. Тиймээс, BSI-ийн баталгаажуулалтыг дэлхий нийтээрээ онцгойлон эрхэмлэж хүлээн авдаг болохыг эдийн засгийн статистик мэдээлэл болон бидний клиент байгууллагуудын хөрөнгийн биржууд дээрх рейтинг баталж байдаг.

### BSI-ийн зах зээл

BSI нь дээд зэрэглэлийн premium class ангилалд ордог хэдий ч үнэ ба чанарын дээд зэргийн тохиролыг хангадаг. Энэ цагт BSI нь дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж яваа стандартын болон баталгаажуулалтын байгууллага ба 175 орны 90 000 байгууллагад үйлчилгээ үзүүлж байна.



**Бизнесийн ертөнц дэхь нэр хүнд**

BSI нь ажил хэрэгч хүрээлэлд онцгой нэр хүндтэй юм. Тухайлбал, хөрөнгийн зах зээлүүдийн статистикаас харахад FTSE (Лондон)-ийн хөрөнгийн биржийн индексд ордог байгууллагуудын 75%, Fortune 500 (АНУ)-ийн шилдэг компаниудын 51%, Hang Seng (Гонконг)-ийн 45%, Nikkei (Япон)-ийн 47% нь BSI-аар баталгаажуулсан байдаг.

BSI-аар үйлчлүүлдэг байгууллагуудын үнэт цаасны өсөлт мэдэгдэхүйц хурдацтай явагддаг ба хөрөнгө оруулалтын өгөөж нь (ROI, ROS, ROA) зах зээлийн дундажаас давсан үзүүлэлттэй байдагийг судалгаагаар тогтоосон байдаг.

2003 оноос эхлэн BSI нь жил бүр дараалан дэлхийн хэмжээний Британы супер брэндээр шалгарсаар байна.

**Мэргэжлийн хүрээлэл дэхь нэр хүнд**

BSI бусад баталгаажуулалтын байгууллагаас ялгарах бас нэгэн онцлог нь стандартуудыг боловсруулж гаргадаг ба тэдгээрийг олон улсын түвшинд хөгжүүлдэг юм. ISO байгууллагын 190 техникийн хороо болон өөрийн 1204 хороодын үйл ажиллагааг удирдан явуулах яцад BSI нь 35,000 стандартуудыг гаргаснаар өнөөдөр дэлхий нийтээр хэрэглэж байна.

BSI-д эхлэлээ тавьсан зарим түгээмэл стандартаас дурьдвал:

- BS 5750:1979 – өнөөгийн ISO 9001 | Чанарын удирдлага
- BS 7750:1992 – өнөөгийн ISO 14001 | Байгаль орчны хамгаалал
- BS PAS 220:2008 – өнөөгийн ISO / FSSC 22000 | Хүнсний аюулгүй байдал
- BS 8800:1996 – өнөөгийн OHSAS 18001 | Хөдөлмөр болон эрүүл мэндийн хамгаалал
- BS 7799-1:1995 – өнөөгийн ISO 27001 | Мэдээллийн аюулгүй байдал
- BS 15000:2000 – өнөөгийн ISO 20000 | IT сервисийн удирдлага
- BS 16001:2009 – өнөөгийн ISO 50001 | Эрчим хүчний удирдлага
- BS 25999:2007 – өнөөгийн ISO 22301 | Бизнесийн тасалдлаас хамгаалах
- BS PAS 55:2008 – өнөөгийн ISO 55000 | Хөрөнгийн удирдлага

**Клиент байгууллагуудын амжилтанд нөлөөлөх байдал**

BSI-ийн үйлчилгээг авахыг дэлхий даяар олон арван мянган амжилттай байгууллагууд эрхэмлэдэг. Тэдний заримаас дурьдвал:

BMW, DuPont, Exxon Mobil, BP, Shell, Pfizer, Motorola, Boeing, Cisco, WalMart, Dell, HP, Johnson & Johnson, Microsoft, Philips, Siemens, GE, GM, Ford, Alcoa, Boeing, BAE Systems, HSBC, American Express, Citi, Barclays, Yahoo, Hitachi, Astra Zeneca, Cable & Wireless, Centrica, Cadbury, LG, Vodafone, Electrica, Rolls Royce, Sony, Ricoh, Sharp, Pioneer, Toyota, Honda, Mercedes Benz, Mitsubishi, Samsung, Sanyo, Fujitsu, Carlsberg, Heineken, Diageo, British Pub Association, UEFA, KPMG, PwC, Deloitte, Saudi Aramco, Exxon Mobil, British Petroleum, Royal Dutch Shell, Chevron, Kuwait Petroleum, Qatar Petroleum, Total зэрэг олон байгууллага байдаг.



BSI нь өөрийн төлөөллийг Монгол улсад бий болгосон ба олон байгууллага бидэнтэй хамтран энэхүү эрхэм хүндтэй гэрчилгээг авах нөхцлийг хангаж дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болоход бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.

### **Ил тод байдал**

BSI-ийн ялгарах бас нэг онцлог нь клиенттэй харилцах ил тод байдал юм. Дэлхийн аль ч өнцөг буланд хоногийн аль ч цагт таны ажил хэргийн түншүүд таны гэрчилгээ хүчин төгөлдөр болохыг шалгах боломжтой. Энэ мэдээллийг манай аль ч вэб хуудсанд байдаг олон улсын мэдээллийн сангаас харна. Ил тод байдал нь таны хэрэглэгч байгууллага, даатгалын компани, хөрөнгө оруулагч байгууллага, үнэлгээний байгууллага зэрэгт болон тендерт оролцоход онцгой үнэ цэнэтэй юм. Холбоос линк нь: [www.bsigroup.com/en/Assessment-and-certification-services/Client-directory](http://www.bsigroup.com/en/Assessment-and-certification-services/Client-directory)

### **Нэр хүнд болон статус**

BSI-д ажилласнаар та мэргэжлийн шилдэг туршлагыг эзэмших ба өөрийн мэргэшлийн түвшин болон ажил хэргийн харилцаа холбоогоо стандарт, сургалт боловсрол, баталгаажуулалтын экспертүүдийн хүрээлэлд байнга хөгжүүлж байдаг гэсэн нэр хүндийг хадгалах болно.

### **Хамтран ажилладаг зөвлөхүүдийн сүлжээ**

BSI нь хараат бус байдлыг хангахаар итгэмжлэлийн байгууллагуудтай зөвшилцсөн олон улсын ACP хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах зөвлөхүүдийнхаа чадварыг байнга ханган хөгжүүлдэг. Ингэснээр бидний клиентүүд удирдлагын стандартчилсан тогтолцоог байгуулах, баталгаажуулах болон дэмжих бүтэн мөчлөгийн хүрээнд бүгдийг хамарсан чанартай, харилцан уялдаатай цогц үйлчилгээ авах боломжтой байдаг.

### **Монгол дахь бидний үйл ажиллагаа**

BSI нь олон улсын стандартын байгууллагынхаа хувьд Монгол улсын засгийн газартай хамтран гурван жилийн хугацаатай "Монгол Улсын стандартын тогтолцоог боловсронгуй болгох" SMMSS төслийн хүрээнд Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн газрын чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлж байна.

Нөгөөтэйгүүр, баталгаажуулалтын байгууллагынхаа хувьд BSI нь Монгол улсын төрийн байгууллагууд, хувийн сектор болон бусад байгууллагуудад олон улсын менежментийн стандартуудыг нэвтрүүлэн баталгаажуулах, энэ салбарын анхны олон улсын мэргэжлийн аудитор, зөвлөхүүдийг бэлтгэх ажлуудыг зохион байгуулах ажлуудыг өрнүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол улсад BSI-ийг төлөөлөн ажиллаж буй х. Б. Ундарлаатай та сонирхсон бүх асуудлуудаараа 8030 8535 утсаар болон [undarlaa.battogtokh@bsigroup.com](mailto:undarlaa.battogtokh@bsigroup.com) мэйл хаягаар холбоо барьж бидэнтэй хамтран ажиллана уу.

2016 оны 12-р сарын 21





Хавсралт А. BSI-ийн гэрчилгээний жишээ



# Certificate of Registration

QUALITY MANAGEMENT SYSTEM - ISO 9001:2008

This is to certify that:

Shell UK Oil Products Ltd  
Oil Sites Road  
Ellesmere Port  
CH65 4FS  
United Kingdom

Holds Certificate Number:

FM 75502

and operates a Quality Management System which complies with the requirements of ISO 9001:2008 for the following scope:

**The manufacture and blending, or sourcing from Shell or others of a range of Lubricating oils to agreed specifications and their storage and distribution.**

For and on behalf of BSI:

Gary Fenton, Global Assurance Director

Originally registered: 21/05/2003

Latest Issue: 17/06/2013

Expiry Date: 17/06/2016



Page: 1 of 1

...making excellence a habit.™

This certificate was issued electronically and remains the property of BSI and is bound by the conditions of contract.  
An electronic certificate can be authenticated [online](#).  
Printed copies can be validated at [www.bsigroup.com/ClientDirectory](http://www.bsigroup.com/ClientDirectory)

Information and Contact: BSI, Kitemark Court, Davy Avenue, Knowlhill, Milton Keynes MK5 8PP. Tel: + 44 845 080 9000  
BSI Assurance UK Limited, registered in England under number 7805321 at 389 Chiswick High Road, London W4 4AL, UK.  
A Member of the BSI Group of Companies.

**Хавсралт В. Монголд сургалт, баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх стандартууд**

BSI нь 2016 оноос эхлэн Монголд дараахь стандартуудаар өөрийн сургалт болон баталгаажуулалтын үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- ISO 9001 | Чанарын удирдлага
- ISO 14001 | Байгаль орчны удирдлага
- BS OHSAS 18001 | Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал
- FSSC 22000 | Хүнсний аюулгүй байдал
- ISO 39001 | Замын хөдөлгөөний аюулгүй байдал
- ISO 27001 | Мэдээллийн аюулгүй байдал
- ISO 20000 | IT сервисийн удирдлага
- ISO 22301 | Бизнесийн тасралтгүй байдал
- ISO 50001 | Эрчим хүчний удирдлага
- ISO 55000 | Хөрөнгийн удирдлага
- BS PAS 99 | Эрсдэл дээр үндэслэсэн удирдлагын тогтолцоонуудын интеграцчилал

Мөн түүнчлэн дээрх болон бусад төрлийн сургалт болон баталгаажуулалтын үйлчилгээг Монгол улсад BSI-ийн дэлхий даяар байрлах оффисууд дахь экспертүүдийг оролцуулан гүйцэтгэнэ.

